

Эх сурвалж: А.Мөнхжаргал
 Дорнод аймгийн Боловсролын газар
 Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот
 Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч
 Емэйл: munkhjargal6lqv@moes.edu.mn Утас: 89336089

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар
(2025 оны жилийн эцэс)

2025.12.24

Чойбалсан хот

Шийдвэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ
УИХ-ын тогтоол					
9	12	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2024-04-18 Дугаар 2024_27	2.2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай.	Боловсролын салбарт хэрэгжүүлэх 2025 оны зорилтот жилийн хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 20 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сургууль, цэцэрлэгийн ёс зүйн дэд хороод жилийн төлөвлөгөөг гаргасан.	100
10	13	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-05-02 Дугаар 2024_37	2.а.а/Бүх шатны боловсролын сургалтын байгууллага, дотуур байрны гадаад болон дотоод орчны аюулгүй байдлын стандартыг хангуулах, боловсролын байгууллагын барилга, өргөтгөлийн ажилд төр, иргэний хамтарсан хөндлөнгийн хараат бус хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх;	Бүх шатны боловсролын сургалтын байгууллага, дотуур байрны гадаад болон дотоод орчны аюулгүй байдлын стандартыг хангуулахад чиглэсэн 1 хяналт шалгалт, 1 эрсдэлийн үнэлгээг хийн ажилласан. Одоогийн байдлаар барилга ашиглалтын шаардлага хангахгүй болон засвар үйлчилгээ хийх шаардлагатай мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан 11 хүүхдийн цэцэрлэг, 6 ерөнхий боловсролын сургууль, 4 дотуур байр байгаагаас 2025 онд 19.0 хувьд нь засвар үйлчилгээ хийгдсэн, 2026 онд 28,6 хувьд нь хөрөнгө оруулалт хийгдэхээр улсын төсөвт тусгагдаад байна. Хяналт шалгалтаар нийт 427 зөрчил дутагдал илэрснээс 257 зөрчлийг арилган, хууль тогтоомжийн хэрэгжилт 60.2 хувьтай хангагдсан. Хяналт шалгалтын хүрээнд сургууль, цэцэрлэгүүдэд тулгамдаж буй засвар үйлчилгээ, хөрөнгө оруулалтын 9 ажлыг багцлан тусгаж, цаашид авах арга хэмжээний 13 саналыг Боловсролын яамны Салбарын хяналтын газарт хүргүүлсэн байна. Мөн Боловсролын газрын даргын 2025 оны А/35 дугаар тушаалаар аймгийн ерөнхий боловсролын сургууль, дотуур	100

Эх сурвалж: А.Мөнхжаргал
 Дорнод аймгийн Боловсролын газар
 Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот
 Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч
 Эмэйл: munkhjargal6lqv@moes.edu.mn Утас: 89336089

				<p>байранд орчны аюулгүй байдлын үнэлгээг хийх ажлын хэсгийг байгуулан, ерөнхий боловсролын 27 сургууль, 16 дотуур байрыг бүрэн хамруулсан. Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын стандартад нийцсэн байдлыг үнэлэхэд бага эрсдэлтэй 21, дунд эрсдэлтэй 6 сургууль, дундаж үзүүлэлт 22.9 хувь буюу бага эрсдэлтэй, 16 дотуур байрын орчны үйлчилгээний стандартын шалгуур үзүүлэлтэд нийцсэн байдлыг үнэлэхэд бага эрсдэлтэй 15, дунд эрсдэлтэй 1, хүүхэд хамгааллын эрсдэлийг үнэлэхэд хангалттай 19, дунд зэрэг 6, хангалтгүй 2 сургууль үнэлэгдсэн. Сургуулиудад орчны эрсдэлийг бууруулах хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласнаар сургуулиуд нийт 246 ажлыг төлөвлөн, 65.0 хувийн биелэлттэй байна.</p>	
14			<p>2.б.б/Хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн эрхийг хангах хүрээнд тэднийг дэмжих төв ажиллуулж, тохирох орчныг бүрдүүлэх, тусгай сургалтын хэрэглэгдэхүүн бий болгох, эцэг, эхийн оролцоог хангаж, багшийн туслахаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, багш, багшийн туслах, ажилтанд нэмэгдэл хөлс олгох хуулиар тогтоосон арга хэрэгслийг үр дүнтэй хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын цогц арга хэмжээ авах;</p>	<p>Хэрлэн сумын ерөнхий боловсролын 12 сургуулийн 15 нийгмийн ажилтан, 4 сэтгэл зүйч, сургуулийн өмнөх боловсролын туслах багш 18, ерөнхий боловсролын 9 багш нийт 46 багш нарыг чадваржуулах “Харааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй брайл үсэг” сургалтад хамруулсан. “Хамтдаа хөгжих–Тэгш оролцоотой ирээдүйн төлөө” өдөрлөгийг зохион байгуулж, 10 хүүхдийг эрүүл мэндийн үзлэг, нөхөн сэргээх эмчилгээнд хамруулсан бөгөөд “Бочи”, “Оргил өөд хамтдаа” тусгай олимпыг 135 хүүхэд, 34 багш, удирдах ажилтан, 108 эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоог хангахад хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй хамтран ажиллаж, багш, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарын сургалт, хэлэлцүүлэг, уулзалт, илтгэлийн уралдаан гэсэн 4 ажлыг хамтран зохион байгууллаа. Багш нарыг чадавхжуулах зорилгоор “Ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулах арга зүй”, “Хараа бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй”, “Брайл үсэг”, “Аутизмын хүрээний эмгэг, анхаарал төвлөрөлт, хэт хөдөлгөөнт эмгэг, суралцахуйн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах арга зүйн” сэдвээр 5 удаагийн сургалт зохион байгуулж, нийт 294 багш, ажилчдыг хамрууллаа. “Хөгжлийн ялгаатай хүүхдийн эрхийн зөрчил, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам–2025” илтгэлийн уралдааныг зохион байгуулж, шалгарсан 3 бүтээлийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын эрдэм шинжилгээний хуралд оролцох 3 илтгэлийг “Хөгжлийн онцлог ялгаатай хүүхдийг хамтад нь сургах арга зүй, хөгжлийг дэмжих арга замууд, туршлага” сайн туршлагын эмхэтгэлд орсон. 2025 онд сургуулийн өмнөх боловсролын 16 байгууллагын 105 багш, 43 ажилтанд 15467616.9 төгрөг, ерөнхий боловсролын 16</p>	100

Эх сурвалж: А.Мөнхжаргал
 Дорнод аймгийн Боловсролын газар
 Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот
 Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч
 Емэйл: munkhjargal6lqv@moes.edu.mn Утас: 89336089

				<p>сургуулийн 119 багш, 13 бусад ажилтан 6667454.88 төгрөг нийт 22135071.8 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш ажилтанд холбогдох хууль тогтоомжид заасан нэмэгдэл, урамшуулал олгосон байна. “Хүртээмжтэй орчныг сайжруулах хүрээнд 14 сургууль 152 сая төгрөгийн хөрөнгөөр ариун цэврийн өрөөгөө шинэчилж (53.8%), 25 сургууль (96.2%) налуу шаттай болсон. Дотуур байр 16-аас 9 нь (56.3%) ариун цэврийн өрөөгөө засварлан тохижуулав. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн эрхийг хангах хүрээнд Хэрлэн сумын 8-р цэцэрлэгт байнгын асаргаатай 8 хүүхдийг хамруулсан дэмжих бүлэг байгуулан тэдэнд тохирох орчныг бүрдүүлж, тусгай сургалтын хэрэглэгдэхүүнээр ханган ажиллаж байна. Дорнод аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд “Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан тохируулгат орчныг нэмэгдүүлэх” чиглэлээр 40 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна.</p>	
УИХ-ын байнгын хорооны тогтоол					
16	24	<p>Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2020-08-26 Дугаар 2020.08.26 №01 ИЦББХ</p>	<p>3.Бүх шатны боловсролын байгууллагын мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, дэд бүтцийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, бэлэн байдлыг үе шаттай хангуулах</p>	<p>Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулиудын цахим сургалт явуулах дэд бүтцийг сайжруулах, интернэтийн хурдыг нэмэгдүүлэх зорилгоор нэгдсэн зохион байгуулалт хийлээ. Үр дүнд нь аймгийн хэмжээнд төрийн өмчийн 23 сургууль "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК (МЦХ)-тай гэрээ байгуулан, шилэн кабелийн өндөр хурдны интернэтэд бүрэн холбогдсон. Сургууль бүрийн интернэтийн хурдыг доод тал нь 20Mbps-д хүргэж, өмнөх үеийн дундаж хурдтай харьцуулахад өссөн. Сүлжээний тасралтгүй найдвартай ажиллагааг хангаснаар цахим хичээл, онлайн шалгалт, багш нарын цахим хөгжлийг гацалтгүй дэмжих техникийн суурь бүрэн тавигдсан. Мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, дэд бүтцийг үе шаттай ханган ажиллаж, Сумын орон нутгийн төсөв, Мобиком групп, иргэдийн дэмжлэгээр гурвансургуулийн мэдээллийн технологийн дөрвөн кабинетийг шинэчлэн засварлаж, хөрөнгө оруулалт хийсэн. Үүнд:</p> <p>1. Хэрлэн сумын 11 дүгээр сургуульд мэдээлэл зүйн кабинетэд сумын хөрөнгө оруулалтаар 51,450,000 сая төгрөгийн тоног төхөөрөмж, мөн тус сургуульд Мобиком групп нь тогтвортой хөгжлийг дэмжих ажлын хүрээнд "Smart Education" төслөөс орчин үеийн дэвшилтэт технологи бүхий иж бүрэн "Дижитал танхим"-ыг байгуулж, хүлээлгэн өгөв. Тус кабинет нь өндөр хурдны интернэт, ухаалаг самбар, зөөврийн компьютер зэргээр</p>	100

Эх сурвалж: А.Мөнхжаргал
 Дорнод аймгийн Боловсролын газар
 Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот
 Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч
 Емэйл: munkhjargal6lqv@moes.edu.mn Утас: 89336089

				бүрэн тоноглогдсон бөгөөд нийт 142,179,773 төгрөг-ийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалт хийгдсэн. 2. Хэрлэн сумын 2 дугаар сургуульд сумын орон нутгийн төсвөөс мэдээлэл зүйн кабинетэд 49,885,000 сая хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж нийлүүлсэн. 3. Хан-Уул сургуулийн мэдээлэл зүйн танхимд М банкны хөрөнгө оруулалтаар 15 ширхэг суурин компьютер хандивласан.	
18	27	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-05-25 Дугаар 2021 №05 БСШУСБХ	1.2/Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрыг стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн шинээр барих, засварлах, өргөтгөх болон стандартын шаардлага хангасан зориулалтын тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах зардлыг шийдвэрлэх;	Дээрээт олон улсын хандивлагч байгууллага болон орон нутгийн санхүүжилтээр Хэрлэн сумын хүүхдийн 3, 4, 5, 8, 9, 11, 12, 15, Булган, Чойбалсан, Матад, Халхгол, Чулуунхороот сумын хүүхдийн цэцэрлэгүүд нийт 100.8 сая төгрөгийн 7 нэр төрөл, Хэрлэн сумын 11, Булган сумын сургуулиудад нийт 26.4 сая төгрөгийн 11 нэр төрлийн шаардлагатай тоног төхөөрөмж, Боловсролын яамнаас хэрэгжүүлж буй GPE төслийн хүрээнд Хэрлэн сумын 1, Халхгол, Баян-Уул сумын сургуулиудад 26 төрлийн нийт 385.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл тус тус нийлүүлэгдэж хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчинг сайжрууллаа. Жилийн эцсийн байдлаар хоол үйлдвэрлэлийн орчин сайжруулсан цэцэрлэг 13-аар, сургууль 5-аар нэмэгдэж нийт орчин бүрдүүлсэн цэцэрлэг, сургуулийн эзлэх хувь 88.6 болж нэмэгдлээ. СӨБ- 30 буюу 96.7%, ЕБС-17 буюу 76.9%	100
	28		1.3/Нийслэл болон орон нутгийн боловсролын асуудал эрхэлсэн нутгийн захиргааны байгууллагад сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хариуцсан орон тоог бий болгож, цалин хөлсний асуудлыг шийдвэрлэх;	Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар 20-ны өдрийн А/137 дугаар тушаал "Бүтэц, орон тоо батлах тухай"-аар Сургалтын орчин, хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан ахлах арга зүйчийн орон тоон дээр ажиллаж байна. Ахлах арга зүйч буюу ТЗ-7 шатлалаар цалинжиж байна.	100
	29		1.10/Орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, аюулгүй хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох, сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний дагуу зохион байгуулах ажлыг эхлүүлэх;	Орон нутагт ерөнхий гэрээний дагуу хүнсний түүхий эд бүтээгдэхүүний худалдан авах ажиллагаа эхлээгүй байна.	100
	30		1.11/2022 оноос эхлэн хуулийн хэрэгжилтэд шаардагдах урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын	Дээрээт олон улсын хандивлагч байгууллага болон орон нутгийн санхүүжилтээр Хэрлэн сумын хүүхдийн 3, 4, 5, 8, 9, 11, 12, 15, Булган, Чойбалсан, Матад, Халхгол, Чулуунхороот	100

Эх сурвалж: А.Мөнхжаргал
 Дорнод аймгийн Боловсролын газар
 Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот
 Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч
 Емэйл: munkhjargal6lqv@moes.edu.mn Утас: 89336089

			төсөвт бүрэн тусгах, аж, ахуйн нэгж, байгууллагын хандив, олон улсын байгууллага, гадаад орнуудын буцалтгүй тусламжийн хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх.	сумын хүүхдийн цэцэрлэгүүд нийт 100.8 сая төгрөгийн 7 нэр төрөл, Хэрлэн сумын 11, Булган сумын сургуулиудад нийт 26.4 сая төгрөгийн 11 нэр төрлийн шаардлагатай тоног төхөөрөмж, Боловсролын яамнаас хэрэгжүүлж буй GPE төслийн хүрээнд Хэрлэн сумын 1, Халхгол, Баян-Уул сумын сургуулиудад 26 төрлийн нийт 385.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл тус тус нийлүүлэгдэж хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчинг сайжрууллаа.	
32	57	Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай 2024-11-06	1.2.Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах;	2025 оны 08 сарын 28-ны зохион байгуулсан багш нарын бага хурлаар "Төрийн албан хаагчийн ёс зүйн манлайлал" сэдвээр ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтан багш нийт 523 хүнд сургалт зохион байгуулсан. Энэ хичээлийн жилд шинээр ажилд орсон цэцэрлэг сургуулийн нийт 45 багшид Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/545 "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм", "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль"-аар мэдээлэл, хэлэлцүүлэг хийсэн байна. Мөн хуулийг сурталчлах, мэдлэг ойлголтыг нэгтгэх хүрээнд 12 сургууль, 23 цэцэрлэг "АХА", 1:6, Алтан хонх зэрэг цэнгээнт тэмцээнийг зохион байгуулж бататгалаа. Нийт 42 сургууль, цэцэрлэг багш ажилчидтай ёс зүйн гэрээ байгуулан ажиллахаас гадна, хамт олны ёс зүйтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгааг авч ажилласан байна. Сургууль, цэцэрлэгийн ёс зүйн хороод жил бүрийн 5 -6 сард хийсэн ажлын тайланг хамт олонд тайлагнаж хэвшээд байна.	100
	58	Дугаар 2024_06 ЕЗДБХ	1.3.Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах.	2025 оны 08 сарын 28-ны зохион байгуулсан багш нарын бага хурлаар "Төрийн албан хаагчийн ёс зүйн манлайлал" сэдвээр ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтан багш нийт 523 хүнд сургалт зохион байгуулсан. Энэ хичээлийн жилд шинээр ажилд орсон цэцэрлэг сургуулийн нийт 45 багшид Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/545 "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм", "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль"-аар мэдээлэл, хэлэлцүүлэг хийсэн байна. Мөн хуулийг сурталчлах, мэдлэг ойлголтыг нэгтгэх хүрээнд 12 сургууль, 23 цэцэрлэг "АХА", 1:6, Алтан хонх зэрэг цэнгээнт тэмцээнийг зохион байгуулж бататгалаа. Нийт 42 сургууль, цэцэрлэг багш ажилчидтай ёс зүйн гэрээ байгуулан ажиллахаас гадна, хамт олны ёс зүйтэй холбоотой	100

Эх сурвалж: А.Мөнхжаргал
 Дорнод аймгийн Боловсролын газар
 Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот
 Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч
 Емэйл: munkhjargal6lqv@moes.edu.mn Утас: 89336089

				сэтгэл ханамжийн судалгааг авч ажилласан байна. Сургууль, цэцэрлэгийн ёс зүйн хороод жил бүрийн 5 -6 сард хийсэн ажлын тайланг хамт олонд тайлагнаж хэвшээд байна.	
35	64	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-06-10 Дугаар 2025_04 ЁЗДБХ	1.1.1. 1/Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган үр дүнд хяналт тавьж ажиллах;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд төрийн албан хаагчийн нэр хүнд, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр ерөнхий боловсролын 27 сургууль, 32 цэцэрлэг 2025 оны жилийн ажлын төлөвлөгөөндөө тусган, хэрэгжилтийг ханган дараах 3 чиглэлээр ажиллалаа. 1. Соён гэгээрүүлэх ажил: Ёс зүйн хэм хэмжээг таниулах, сурталчлах, сургалт, лекц, хэлэлцүүлэгт нийт багш, албан хаагчдын 96 хувь хамрагдсан. 2. Урьдчилан сэргийлэх ажил: Ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хүрээнд "Удирдлагын манлайлал", "Өглөөний цай", "Хамтдөө хөгжье" зэрэг эерэг, нөлөөлийн ажлуудыг давхардсан тоогоор 128 удаа зохион байгуулж, 3000 гаруй багш, удирдах ажилтан, албан хаагчийг хамруулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, контентыг байгууллагын цахим хуудсаар түгээн дэлгэрүүлсэн. Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих: байгууллагын дэргэдэх ёс зүйн зөвлөлийг чадавхжуулахад анхааран ажиллаж, хэрэгжилтийг хангахад байгууллагын удирдлагын зүгээс үйл ажиллагааг дэмжин, оролцоог хангах, ёс зүйн булан байгуулах, байгууллагын албан хаагчдыг ёс зүйн чиглэлийн хэлэлцүүлэг, сургалтад хамруулах арга хэмжээг 27 сургууль, 32 цэцэрлэг хэрэгжүүлсэн.	100
	65		1.1.3. 3/Монгол Улсын Ёс зүйн хорооны гишүүдийн, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийх.	Боловсролын газрын даргын 2024 оны А/22 дугаар тушаалаар байгуулагдсан, 5 хүний бүрэлдэхүүнтэй ёс зүйн дэд хороо нь ёс зүйн хорооны жилийн төлөвлөгөөтэй уялдуулан салбарын ажилтнуудын ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гарсан зөрчлийг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлж, Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Захиргааны ерөнхий хууль болон холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд тулгуурлан ил тод байдал, хариуцлага, хараат бус байдлыг ханган ажилласан. Ёс зүйн хорооны хорооны гишүүдийг удирдлага, боловсролын менежмент, сэтгэл зүй, хууль эрх зүйн мэдлэгтэй ажилтнуудаас тэнцвэртэй бүрдүүлэх, гишүүдийг	100

Эх сурвалж: А.Мөнхжаргал
 Дорнод аймгийн Боловсролын газар
 Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот
 Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч
 Емэйл: munkhjargal6lqv@moes.edu.mn Утас: 89336089

				сонгохдоо тухайн асуудалд ашиг сонирхлын зөрчилгүй байх шалгуурыг хатуу мөрдүүлэх, ёс зүйн зөрчил хэлэлцэх үед тухайн байгууллагын удирдлагаас хараат бус хуралдааны хэлбэрийг ашиглах, хараат бус, бие даасан байдлыг илүү баталгаажуулах, гишүүдийн чадавхыг нэмэгдүүлэхэд анхаарч, зохицуулалтыг хийсэн. Тус онд байгууллагын ажилтан болон боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтнуудын ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол ирээгүй болно.	
	66		1.3.1.1/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн үр дүнг тооцож ажиллах.	Төсвийн тухай хуулийн 12.1.17-д заасны дагуу төсвийн орлогын бүрдэлтэй холбоотой урамшууллын зардлын санхүүжилт болон зарцуулалтын зрхийг бууруулсан тул 2025 онд ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажилласны урамшуулал олгоогүй.	100
Ерөнхийлөгчийн зарлиг					
36	67	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх 2018-05-23 Дугаар 2018_46 туай	3.Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Ерөнхий боловсролын 23 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 26 цэцэрлэг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалт төлөвлөж 586 багш ажилчдын унших, бичих чадварыг хөгжүүлж ажилласан байна. Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөл, иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын алба хамтран албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах сургалт, зөвлөн туслах үйл ажиллагааг танхимаар болон цахимаар 3 удаа давхардсан тоогоор 102 архив, бичиг хэрэг хариуцсан ажилтанд зохион байгуулсан. Хэрлэн сумын 5-р сургуулийн мэдээллийн хуудсыг хос бичгээр хэвлэн гаргаж байна. Мөн цахим хуудаас мэдээ мэдээллийг хос бичгээр нийтлэх ажлыг зохион байгуулах ажлыг МХБУЗ багш нар хариуцан ажиллаж байна. 10-11-р ангийн сурагчдын дунд "Монгол бахархал" сэдвээр "Экстемп илтгэл"-ийг сурагчдын үндэсний бичгийн хичээлээр эзэмАшсэн мэдлэг, чадварыг сорих, эцэг эх, сурагчдын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор зохион явууллаа. Бүх нийтийн эх хэл, үндэсний бичгийн боловсролд зориулан нээсэн, өөрийн хөтлөн явуулдаг Матад сумын "Эх хэл бичиг соёлоо эрхэмлэгчид" 282 гишүүнтэй группээрээ дамжуулан монгол хэлний дүрмийг тогтмол танилцуулан, зөв бичих чадварыг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллаж байна. Ерөнхий боловсролын 12 сургууль цахим орчинд мэдээ мэдээллийг хос бичгээр бичиж, пэйж хуудсанд 76 мэдээ байршуулан түгээн дэлгэрүүлэлт хийсэн байна. Ерөнхий боловсролын 23 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 26 цэцэрлэг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг,	100

Эх сурвалж: А.Мөнхжаргал
 Дорнод аймгийн Боловсролын газар
 Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот
 Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч
 Емэйл: munkhjargal6lqv@moes.edu.mn Утас: 89336089

				чадварыг дээшлүүлэх сургалт төлөвлөж 586 багш ажилчдын унших, бичих чадварыг хөгжүүлж ажилласан байна. Дорнод аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөл, Хэрлэн сумын 12 дугаар сургуулиас зохион байгуулдаг үндэсний бичгийн цахим бичвэрийн уралдаан 4 дэх жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. Энэ жилийн уралдаан хүрээгээ тэлж, мэргэжлийн багш, Бусад мэргэжлийн багш, бага ангийн багш, төрийн албан хаагч, сурагч /ахлах, дунд/ гэсэн 5 ангиллаар зохион байгуулагдсан бөгөөд нийт 100 гаруй хүн оролцож, үндэсний бичгийн мэдлэг чадвараа сорив. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын 60 байгууллага гаднах хаягаа стандартын дагуу хийлгэсэн.	
37	68	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104	1.16.Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих	Мэргэжлийн байгууллагын зөвлөмжөөр Хэрлэн сумын 1, 5, 8, 12, Хан-Уул сургуулийн ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт сургуулийн хүүхэд хамгааллын баг, хоол зүйч нар хамтран ЭМС-ын А/370 дугаар тушаал Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалт батлах тухай” тушаалыг танилцуулан, цаашид тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлэн хяналт тавьж ажиллалаа. Жилийн эцсийн байдлаар 10 аж ахуй нэгжид зөвлөмж хүргэж, тушаалыг танилцуулах ажлыг 100 хувь гүйцэтгэсэн.	100
40	75	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159	3.Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай.	Боловсролын бүх шатны байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залах үйл ажиллагааг зохион байгуулсан. Жил бүрийн өвлийн тэргүүн сарын шинийн нэгний өдрийг “Монгол бахархал”-ын өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлдэг. Уг өдрийг тохиолдуулан бүр Эзэн Богд Чингис хааны түүхэн гавьяа, үлдээсэн өв соёл, түүх уламжлалт ёсоороо бахархах түүхэн зүтгэлтнүүдийн үйл хэргийг сурталчилан таниулах, бүтээл туурвилыг түгээн дэлгэрүүлэх зорилготой олон талт үйл ажиллагааг зохион байгуулдаг.	100
	76		4.Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай.	Чингэс хааны мэндэлсэн өдрөөр хүүхэд залуучуудад түүхэн бахархлыг мэдрүүлэх, улмаар эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх, Чингис хааны үнэнч, шударга, эв нэгдэлтэй байх тухай сургаалыг өдөр тутмын амьдрал, хүмүүжилд хэвшүүлэх зэрэг олон талт үйл ажиллагааг зохион байгуулсан. МХУЗ-ын багш нар “Монгол бахархал”-ын өдрийг угтан 10-р ангийн сурагчдын дунд “Монголын нууц товчоог хэн сайн мэдэх вэ?” АХА тэмцээнийг 18 сургуулийн сурагчдын дунд зохион байгуулсан бөгөөд 320 гаруй сурагчид оролцсон.	100

Эх сурвалж: А.Мөнхжаргал
 Дорнод аймгийн Боловсролын газар
 Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот
 Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч
 Эмэйл: munkhjargal6lqv@moes.edu.mn Утас: 89336089

42	78	Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай 2025-04-03 Дугаар 2025_44	1.Жил бүрийн 5, 9 дүгээр саруудын Бямба, Ням гарагуудыг тэрбум мод тарих үндэсний өдөр болгон зарласугай. 2. Тэрбум мод үндэсний өдрийн хүрээнд бүх нийтээр мод, сөөг тарих, арчлан ургуулах үйл хэрэгт идэвхтэй оролцож, сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэхийг Монгол Улсын нийт ард иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хөгжлийн түнш байгууллагууд, хандивлагч нарт уриалсугай.	Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилга “1 тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2016 оны А/38 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2016 оны А/388 дугаар захирамж, Хэрлэн сумын Засаг Даргын 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 3/1345 дугаар албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Бүх мод тарих үндэсний өдөр”-ийн арга хэмжээний намрын тарих ажлыг тус газар 2025 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Хэрлэн сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэр дэх шинээр хашаажуулсан 10.0 га талбайд байгуулсан “Байгууллагын төгөл”-д мод тарих ажлыг амжилттай зохион байгууллаа. Мод тарих ажилд нийт 2 техник хэрэгсэл, 23 албан хаагч оролцож тарилтыг 3 эгнээгээр /эгнээ хоорондын зай 3м, мөр хоорондын зай 3 метр, тогооны гүн 80см, диаметр 70см/-ээр тооцон суулгацын тогоо бэлтгэж, нийт 20 ширхэг таримал улиасны 1, 2 наст суулгацыг шилжүүлэн тарилаа. Ажлын үеэр хөрсөнд хийх хар шороог ойролцоох Гэрэл сэтгэмж ХХК-ний мод үржүүлгийн газраас татан авч бэлтгэн хөрсийг бордох ажлыг зохих хэмжээгээр хийж гүйцэтгэв. Мод тарих ажлыг хийж гүйцэтгэсний дараа цэнэг усалгаа хийлээ. Мөн тус үйл ажиллагааны хүрээнд өөрийн байгууллагын эдэлбэр газрын мод, бутыг хэлбэржүүлэн таналт, тайралт хийж, модыг хорхой шавьжаас хамгаалан, өнгө үзэмжийг нь нэмэгдүүлэх зорилгоор модны ероолоос дээш 1 метр орчим хэсгийг шохойдон будаж, байгууллагын гадна 14 2 талбайд 1 наст цэцгийн мандал тарьж ургуулж байна.	
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл					
137	212	2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11	XII.5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендэрийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж байна. Үүнд: Боловсролын газар нь 2025 оны 01 дүгээр сарын 04-ны өдөр ерөнхий боловсролын 26 сургууль, 32 цэцэрлэгт жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хяналтад авсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний маягт боловсруулан хүргэж 2025 оны 01 дүгээр сарын 08-ны дотор төлөвлөгөөг боловсруулж батлуулан ирүүлэх чиглэл өгсөн бөгөөд тайлагналтын үед 26 сургууль, 32 цэцэрлэг ирүүлсэн.(100%) Тайлант хугацаанд 24 сургууль 763 багш, ажилтанд, 31 цэцэрлэг 480 багш, ажилтанд төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж цаашид анхаарах асуудал, арга хэмжээг тодотгосон,	100

Эх сурвалж: А.Мөнхжаргал
 Дорнод аймгийн Боловсролын газар
 Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот
 Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч
 Емэйл: munkhjargal6lqv@moes.edu.mn Утас: 89336089

				<p>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахад 26 сургууль, 33 цэцэрлэг, мэргэжлийн боловсролын 2 сургуульд хяналтад авсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, төлөвлөгөө боловсруулах маягт, жендэрийн эрх тэгш байдлын хангах тухай хууль, боловсролын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого зэрэг 4 чиглэл бүхий холбогдох баримт бичгийг тус тус хүргэж нэгдсэн удирдлагаар ханган ажиллаа. Зөвлөн туслах ажлын хүрээнд Гурванзагал, Дашбалбар, Булган, Сэргэлэн сумдын сургууль, цэцэрлэгийн жендэр хариуцсан нийт 8 албан хаагчдад хяналт тавьж мэдээлэл өглөө.</p>	
142	219	<p>2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23</p>	<p>XXII.2.“Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах.</p>	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах, төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас https://manage.gov.mn/ болон шил ажиллагааны https://shilen.gov.mn/ системд 2025 оны 2,3,4 дүгээр улиралд мэдээллийг хугацаанд нь оруулж хэвшсэн. Нийт 78 үзүүлэлтээс чиг үүрэгт хамаарал бүхий 46 үзүүлтээр мэдээллийг оруулж, 3 дугаар улиралд 91.39 хувьтай үнэлэгдэж, өмнөх улирлаас 5.8 хувиар ахисан байна. Мөн байгууллагын https://dornodedu.mn/dornodedu/?p=4261 вэб хуудас болон Дорнод аймгийн Боловсролын газар пэйж хуудсаар боловсролын салбарын мэдээ, мэдээлэл, үйл ажиллагааг тогтмол түгээн, мэдээллээр ханган ажиллалаа. Вэб хуудсанд 3-р улиралд 33, 4-р улиралд 33, нийт 66 мэдээллийг байршуулан, ил тод байдлыг хангасан.</p>	100
148	229	<p>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр</p>	<p>20.11.1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод,</p>	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах, төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас https://manage.gov.mn/</p>	100

Эх сурвалж: А.Мөнхжаргал
 Дорнод аймгийн Боловсролын газар
 Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот
 Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч
 Эмэйл: munkhjargal6lqv@moes.edu.mn Утас: 89336089

		сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэл 2024-04-17 Дугаар 2024_15	нээлттэй байлгах аргаар заасан мэдээллийг "Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)"-д байршуулах ажлыг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, мэдээллийг тухай бүр шинэчилж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой байгууллагуудын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; (Шил" ажиллагааны хэрэгжилтийн талаар)	болон шил ажиллагааны https://shilen.gov.mn/ системд 2025 оны 2,3,4 дүгээр улиралд мэдээллийг хугацаанд нь оруулж хэвшсэн. Нийт 78 үзүүлэлтээс чиг үүрэгт хамаарал бүхий 46 үзүүлтээр мэдээллийг оруулсан. Вэб хуудсанд 3-р улиралд 33, 4-р улиралд 33, нийт 66 мэдээллийг байршуулан, ил тод байдлыг хангасан.	
177	275	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-02 Дугаар 2025_15	10.4.1.Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг доор дурдсан албан тушаалтнуудад даалгав: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг үнэн зөв, иргэдэд ойлгомжтой байдлаар цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд 2025 оны 10 дугаар сарын 01-ний дотор бүрэн байршуулахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах, төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас https://manage.gov.mn/ болон шил ажиллагааны https://shilen.gov.mn/ системд 2025 оны 2,3,4 дүгээр улиралд мэдээллийг хугацаанд нь оруулж хэвшсэн. Нийт 78 үзүүлэлтээс чиг үүрэгт хамаарал бүхий 46 үзүүлтээр мэдээллийг оруулсан. Вэб хуудсанд 3-р улиралд 33, 4-р улиралд 33, нийт 66 мэдээллийг байршуулан, ил тод байдлыг хангасан.	100
ЗГ-ын албан даалгавар					
187	318	Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай 2025-06-18 Дугаар 2025_01	1.2.Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах;	Салбарын удирдлагын манлайллыг нэмэгдүүлэх төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллахад анхаарч харилцааны алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Боловсролын газар, сургууль, цэцэрлэгүүд пэйж хуудсаар дамжуулан ёс зүйн мэдээлэл, хүүхэд хамгааллын талаар зөвлөгөө, зөвлөмж, бичлэгийг тогтмол байршуулж ажилласан байна. 18 сургууль, 14 цэцэрлэг багш ажилчдад эерэг харилцаа бий болгох, багийн ажиллагааг дэмжихийн тулд олон талт үйл ажиллагаа тогтмол зохион байгуулсан байна. Сургуулийн нийгмийн ажилтнууд 15 сургуулийн 1420 багш, ажилчдад "Эерэг харилцааг өөрөөсөө" сэдвээр сургалт дадлага хосолсон үйл ажиллагааг явуулснаар багш нар бие биенээ хүндлэх, бусдын орон зайд халдахгүй байх чадваруудыг дадлага хийх явцдаа эзэмшсэн.8 сургуулийн багш нарт "Бие биенээ хүндэлж, хайрлаж" уриан дор зохион байгуулж,	100

Эх сурвалж: А.Мөнхжаргал
 Дорнод аймгийн Боловсролын газар
 Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот
 Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч
 Емэйл: munkhjargal6lqv@moes.edu.mn Утас: 89336089

				бие биендээ урмын үг хэлцгээж эерэг уур амьсгалыг бий болгон ажилласан.	
189	353	Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-07-25 Дугаар 2025_04	1.3.Иргэддээ чин шударгаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад;	Багш бүр "Ес зүй, манлайлалтай ажиллахад анхаарч ажилласан. Дорнод аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Багшийн ёс зүйн дэд хороотой хамтран "Эцэг эх, багш нар хүүхдэд хэрхэн анхаарал хандуулдаг вэ", "Багшийн дүр төрх", "21-р зууны багш" зэрэг сэдвүүдээр сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 18 байгууллагын 827 багш хамрагдлаа. 2025 оны 4 дүгээр сард Боловсролын газраас хаврын төгсөлтийн баярын үед ангийн эцэг эхчүүдээс аливаа төрлийн бэлэг, шан харамж авахгүй байх, сургуульд хүүхэд элсүүлэхэд хандив, хууль тогтоомжид зааснаас бусад төлбөр, хураамж авах, ном, гарын авлага болон бусад сургалтын материал, сонин зэргийг сурагчдад худалдан авахыг тулган шаардахгүй байх талаарх зөвлөмжийг 59 удирдах ажилтанд танилцуулан, төгсөх ангийн буюу 5 болон 9, 12 дугаар ангийн суралцагчдын 6037 эцэг эх, асран хамгаалагч нарт дээрх зөвлөмжийг танилцуулан ажилласан байна. Ажлын байран дахь сэтгэцийн эрүүл мэндийг чухалчилъя" уриан дор ярилцлага, контент, постер хэлбэрээр 44 удаагийн мэдээллийг сургуулиуд цахим бүлэгт байршуулсан. Мэдээллийг сургуулийн багш, ажилтан, эцэг эх олон нийтэд хүргэн ажилласнаар энэ төрлийн аливаа гомдол ирээгүй болно.	100
	354		1.4.Төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцээн байгуулж ажиллуулахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагад;	Хүүхдийн цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуулиуд 5-7 хүний бүрэлдэхүүнтэй багшийн ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулсан.	100